

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД, ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар А/71, А/55

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- 1."Төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч болон бусад холбогдох байгууллагуудад даалгасугай.
- 3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 130/190 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- 4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Л.ХАЛТАР

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА П.ОДОНБААТАР